



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/482

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн “Монгол-Алтай” дугуйн холбооноос санаачлан зохион байгуулж байгаа “Ховд-4x108” Баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах зардалд 3 000 000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Тэмцээнд зарцуулагдах 3000 000 төгрөг /Гурван сая /-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 5.17-д тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/ нарт тус тус зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2020 оны  
08 дугаар сарын 13-ны өдрийн  
А/432 дугаар захирамжийн хавсралт



**“ХОВД -4Х108” БАРУУН БҮСИЙН ДУГУЙН АВАРГА  
ШАЛГАРУУЛАХ ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ**

Д/д	Арга хэмжээ	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Шагнал	1	500000	500000
2	Автобусны үнэ	1	2000000	2000000
3	Хоол хүнс	1	450000	450000
4	Ариутгал эмч	1	50000	50000
	<b>Нийт</b>			<b>3 000 000</b>

-oOo-